

Газар эзэмших эрхийн талбайн
хэмжээ өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 31 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших, ашиглах эрхийн талбай хэмжээ, зориулалт өөрчлөгдөж байгаа нэр бүхий 2 /хоёр/ иргэний газар эзэмшил ашиглалтын талбайн хэмжээнд өөрчлөлт оруулж хавсралтаар баталсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2018 оны А/328 дугаар захирамжийн Аюурзана Ариунтуяа, 2012 оны А/244 дүгээр захирамжийн Баатар Баярцэцэг нарт холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

3. Газар эзэмшил, ашиглалтын талбайн хэмжээ өөрчилсөн иргэдтэй газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн авч, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газрын алба /Ж.Мөнх-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ